

Z. Junaa, elderly woman gives an interview with her husband and one visitor to the house. Ger, Khovd, August 2012. Interview is taken by Irina Morozova in the presence of Enkhbaatar Munkhsaruul and some assistance of the interpreter.

- ***Где она, когда родилась, кто были родители?***
- ***Эмээ та хэдэн онд, хаана төрсөн бэ?*** (male voice/the interpreter)
- Би 1925 онд тэр Хятадын нутагт. Чингэл цагаан уул гэдэг газар төрсөн. Чингэл гээд газар. Тийм, Чингэлд төрсөн.
- ***Танай аав ээж юу хийдэг хүн байсан бэ?***
- Миний аав ээж малчин хүн байсан. Хөдөөнийх.
- ***А в каком году?***
- **Interpreter:** в 1925 году в Китае, так называемой Чингэл, в таком месте она родилась.
- ***Как интересно, расскажите пожалуйста, как вы... о вашем детстве, что вы помните?***
- ***Enkhbaatar: Та тэгээд эмээ хүүхэд насаа тэр Хятадын газар өнгөрүүлсэн юм уу? Хятад улсад?***
- Тэр 1929 онд билүү наашаа нь улаан цэрэг очоод, тэр нутгийг наашаа авчирсан юм.
- Тэнд нэг сум байсан байхгүй юу. Тэнд төрсөн юм байна л даа. 1929-1930-аад оны үед эндээс цэргүүд очиж, улаан цэргүүд очиж, тэгээд тэнд чинь одоо урианхай улсууд их байсан. Энэ хүн чинь урианхай хүн л дээ. Урианхай, торгууд, казак, чантуу тийм улсууд их байсан. Тэр улсуудыг одоо авчирсан байхгүй юу, тасалж. Тэгээд одоо ирээд Баян-Өлгий аймгийн Булган суманд амьдарч байгаад энд ирээд ажил төрөл хийгээд насаараа энэ Цагдаагийн газрын үйлчлэгч ажлыг насаараа хийж байгаад тэтгэвэртээ гарсан хүн. Ийм л самган, чаваас гэж. ***(replied by her husband)***
- Би 1948 онд Цагдаагийн газарт ажилд орсон хүн. 1948 оноос тэгээд 80-н хэдэн он хүртэл ажиллаж байгаад тэгээд тэтгэвэртээ гарсан.
- Тэрээр 1985, 1986 он хүртэл ажиллаад тэгээд тэтгэвэрт гарсан хүн. Тийм л амьдралтай хүн. Одоогоор яахав дээ ганцаар, ганц бие хүн л дээ. ***(replied by her husband)***

- Манай энэ хүн бол одоо сурвалжлагч хүн байсан. Яваагүй газар байхгүй. Тэр Хэнтийн нутгаар явж байсан байх, Увсын нутгаар ч явж байсан байх.
- Би гадаад дотоодоор ч их явж байсан. Энэ одоо МОНЦАМЭ байна шүү дээ, манай монголын тэнд одоо сурвалжлагч байсан хүн л дээ, уул нь. Тэгээд л одоо тухайн үедээ яахав жаахан яриа хөөрөөнөөс болоод, янз бүрийн юмнаас болоод буусан хүн л дээ. Тэгээд энд ирээд энэ хөгшинтэй амьдраад, тэгээд энэ юунд эхлээд энэ номын сангийн эрхлэгч хийж байсан, тэгээд дараагаар нь энэ аймгийн хөдөлмөр сонин гээд байсан. Тэрний хариуцлагатай нарийн бичгийн дарга гэж хийж байв. Тэгээд сүүлд нь Музейн захирал хийж байгаад, музейгээс тэтгэвэрт гарсан.

(replied by her husband)

- ***(Interpreter: 1929 году их взяли красная армия, здесь победила революция и за них они поехали до Китая. Там “Чингэл”-тэй её родное место, там поехали. Они взяли собой на территорию Монголии. Сначала она жила в сомоне Булган Баян-Улгийского аймака, а потом она сюда приехала и здесь в 1948 году она стала работать полицейском учреждений уборщицей до 1985 года)***
- ***Может, у неё спросите, - как её жизнь, как жилось, как она жила в тот период 40-ых до 85-х?***
- ***Interpreter: Эмээ таны амьдарч байх үед одоо 48 оноос 1980-н хэдэн он хүртэл социализм тогтож байсан ш дээ. Тэр үед амьдрал ахуйд нь ямар байв, социализмд? Ардчилсан хувьсгал 90-н онд ялаад тэрнээс хойш амьдрал ахуй ямар болов, энэ талаар та юу гэж бодож байна?***
- Тэрийг чинь ер нь дээр үед... тэр эх орны дайны үед их хэцүү байлаа ш дээ, ерөөсөө. Тэр үед их хэцүү байсан. Юм ховор. Ганц удаа даавуу, даалимба нь хүртэл үнэтэй цайтай. Юм нь олддогүй, ховор байсан. Тэрнээс хойш... энэ одоо тэгээд тэр дайн дуусаад, тусгаар тогтноод амьдрал сайхан болсон улсуудын. Одоо яахав болж л байна ш дээ, одоо. Нээх муу биш, сайхан биш. Юм жаахан үнэтэй цайтай болж байна. Тэрнээс биш одоо, дээр үед чинь мөнгөний ханш өндөр байсан монголын, одоо мөнгөний ханш гэж байхгүй цаас болсон байна. Хоёр өөр төрөл байна.

- **(Interpreter:** Во время войны было очень тяжело. Такие... ну, шерстяные материалы были очень дорого. После войны страна, наша общество менялась на социалистическое общество и жизнь стала нормально. При социализме качество деньги очень хорошо было. А сейчас при демократизаций деньги стали очень выше стали, ещё дорого)
- ***А сколько... какая у неё была зарплата когда она работала уборщицей в полиции?***
- ***Таныг цагдаад ажилд байхад таны цалин хэд байсан бэ?***
- 200 байсан.
- 180-200 хооронд байдаг байсан. ***(Replied by her husband)***
- Анхандаа 160 байсан. Тэгснээ өссөөр, өссөөр 180, тэгээд сүүлд нь 200 болсон. Хамгийн сүүлд нь.
- ***200 төгрөг гэсэн үг үү?***
- Тийм 200 төгрөг. Яг одоо байгаагаар 200 төгрөг. Одоо хоёр хайрцаг шүдэнзний үнэ.
- ***(Interpreter:* сначала было 160 тугриков, а потом 200 тугриков)**
- ***А муж сколько зарабатывал?***
- ***А танай хөгшин хичнээн төгрөгний цалин авдаг байв ээ эмээ минь, тэр үед?***
- Дээр үед сурвалжлагч хийж байх үедээ тэр явснаараа, хийснээрээ авдаг байсан. Сүүд нь энэ хэвлэх үйлдвэрт ороод, номын санд ороод, музейд ороод ингэж байх үедээ 300 ч авч байсан юм. Хэвлэх үйлдвэрт ороод нарийн бичгийн дарга хийж байх үед 600 ч авч байсан.
- Тэр үед 350-650 хооронд л авч байсан. Дээд мэргэжлийн хүнийх. ***(Replied by her husband)***
- Тийм... том даргын цалин байсан, нилээн том даргын. Биднүүсийн цалинг бол ер нь 200.
- Хөдөлмөрийн сонины хариуцлагатай нарийн бичгийн дарга хийж байхдаа болбол 650 төгрөгний цалинтай байсан. Тэрнээс одоо энэ музейн захирал, номын сангийн захирал хийж байх үед бол хэлбэлзэлтэй юм л даа 350-500 төгрөгний хооронд байсан. ***(replied by her husband)***

- **(Interpreter:** он работал не только директором музея но и директором библиотека аймачного, и еще здесь была такая редакция газеты где он работал директором, перед этим он занимался репортёром, он взял репортаж. МОНЦАМЭ агентлаг, вы знаете, это национальный телевизионный канал там он работал сначала, а потом здесь. ***Это канал был центральный или именно вот Ховдийский?*** Центральный государственный. Когда работал репортёром, он очень много путешествовал в разных странах чтобы собирать информацию и сделать репортаж. ***Какой у него была образования, какой университет он закончил ?*** Кстати, когда он работал директором этой редакций он зарабатывал 650 тугриков)
- ***Эмээ тэр танай хөгшин ямар мэргэжилтэй хүн байсан бэ?***
- Сэтгүүлч.
- ***А где он здесь в Ховде заканчивал или Улаанбаатаре?***
- ***Хотод Улаанбаатарт сэтгүүлч байсан уу эсвэл гадаадад уу?***
- Тийм Улаанбаатарт. МОНЦАМЭ-д байсан байхгүй юу. Сургуульд төгсөөд Монголын цахилгаан мэдээ агентлагад. (Replied by her husband)
- ***А часто Вы в Улаанбаатар ездили?***
- ***Тухайн үед та Улаанбаатар луу их явдаг байсан уу?***
- Үгүй. Явдаггүй байсан. ***(Both replied)***
- ***Та Улаанбаатар луу очиж үзээгүй юу?***
- Очиж үзсэн. Тэгэхдээ олон удаа яваагүй.
- ***А в другие страны вы ездили?***
- ***Аль нэг гадаадын улс орон руу Та явж байсан уу?***
- Үгүй.
- ***А вы помните когда вот этот музей основывался в те годы помните? В какие? 60-ые годы он был основывон, или когда?***
- ***Энэ музей хэдэн онд анх суурь тавигдаж, баригдсан юм бэ?***
- Энэ чинь одоо 1961 он л доо. Энэ барилга нь болбол 1961 онд баригдсан барилга байхгүй юу. Суурь нь бол нилээд эрт л дээ. Үүнийг чинь 14 хоногт л барьсан ш дээ. Анхны суурь нь бол одоо бүр энэ чинь музей биш зүгээр одоо орон нутгийн судлах кабинет гэдэг нэртэй байсан

байхгүй юу. Тэгээд жаахан үзмэртэй. Тэрнээс хойш баяжуулагдсан. Ингээд 1930-н хэдэн оноос хойш баригдсан. 1946 - 47 оны үед байгуулагдсан байх гэж бодож байна. Энэ барилга бол яг 1961 онд байгуулагдсан. 14 хоногт барьж дуусгасан барилга. Энэ Ховдын хөдөлмөрчид ажилчид барьж байсан байхгүй юу. 14 хоногт барьж дуусгасан барилга. Одоог хүртэл ашиглалтанд ингээд байж байгаа. Засвар хийчихээд л байж байгаа. *(replied by her husband)*

- **(Interpreter:** Сначала основа этого музея поставлен уже трицатые годы, сначала был кабинет краевидческого исследования. А потом 40-х годов немножко стал больше, потом 1961 году построили этот здания в который мы были сейчас. Это построили работники в течение 14 дней).
- ***А вот она сказала, что она до 85-го года работала уборщицей. А после 85-ого года, что она делала?***
- ***Эмээ та тэгээд 85 хэдэнд тэтгвэрт гарснаас хойш юу хийсэн бэ?***
- Энд радио релейны цех гэж энд байж байхдаа нэг сахиул хийгээд, нэг 6 жил хийлээ. Тэгээд л суулаа.
- **(Interpreter:** Здесь такой радио цех был. Она проработала в качестве охранника 6 лет.)
- ***Аа... радио комитете? Вот.. она помнит какую-нибудь, не знаю, там мероприятие, куда она ходила вместе с мужем в связи с музеем, с выставкой, ну вот что-то такое... жизнь 80-х годов помнит?***
- ***Та ингээд хөгшинтэйгээ ямар нэгэн тийм музейн шугамаар ч юмуу аль нэг арга хэмжээнд очиж оролцож байсан уу, ямар нэгэн тийм арга хэмжээнд?***
- Үгүй, тийм арга хэмжээ байхгүй. Надад арга хэмжээ байхгүй. Тэр тухайн үед нэг ажиллаж байсан аймгийн хөдөлмөр сонинд ч овоо сайн ажилчин гэж гарч байсан, Улаан од сонинд ч гарч байсан. Тэр гайгүй ажилтай байсан байлгүй, нас залуу байсан цаг болохоор гайгүй гэж гарч байсан болохоос иймээ тиймээ юм надад байхгүй.
- **(Interpreter:** она не участвовала вместе с мужем, в некоторых газетах про неё писали, что она хорошо работала.)
- ***Аа... сохранились это газета? Люди обычно хранят.***

- Аймгийн хөдөлмөрийн сонинд гарсан. Хэдэн онд гарсан юм мэдэхгүй, одоо ер нь, наадах чинь. Их бүдэг муухай болсон байна.
- ***Она помнит какого года?***
- ***Хэдэн оны сонин бэ, эмээ?***
- Харин хэдэн оных наадах сонин мэдэхгүй ээ, Сая л нэг юм хайж байсан чинь, сонин дотроос гарч ирлээ. Тийм. Наадах чинь бол минийх байлээ. 70-н хэдэн оны үе юм уу, 60-н хэдэн оны юм уу. 60-н хэдэн оны л юм болов уу. 50-н хэдэн оных арай биш байх.
- ***Как она помнит, что менялась в жизни Ховда 80-ых годов?***
- Нилээн хөгшин болсон хойно гарсан байх л даа тэр. Түрүүний гарсан сонинуудын хайчилбарууд яасан юм мэдэхгүй ээ. Гарсан байсныг авсан л байх.
- ***Эмээ, 80-аад он гэхэд урьднихаасаа энд Ховдод амьдралын байдал хир өөрчлөгдсөн бэ, ер нь юм юм?***
- Юм юм тэгээд 80-аад оноор юмны үнэ....одоо юм байна. Чадалтай мөнгөтэй хүн бол мөнгөгүй гэж хэлж болохгүй. Мөнгө муутай, тэгээд чадал муутай, тэтгэвэр мэтгвэрчгүй, юу ч үгүй тийм хүнд бол хүнд байна. Бид нар яахав тэгээд, би нэг сарын 180 мянган төгрөгний тэтгвэр авдаг. Тэгээд амьдраад байдаг.
- ***80 онд танай амьдрал хир байсан бэ?***
- 80 онд манай амьдрал сайн байсан. Манай энэ хүн ажилтай байсан. Сайн байсан даа. Манай амьдрал болбол сайн байсан. Одоо тэгээд ганц бие тэтгэврээр нь амьдарч байна. Одоо тэгээд хоосон хонохгүй, хоёр идэхгүй гэдэг нэг үг байдаг манай монголын. Тэрүүгээр л байж байна.
- **(Interpreter: 80-ых годах она жила с мужем, очень хорошо тогда. Сейчас она на пенсии, 180 тысячи тугриков за месяц.)**
- ***Почему она тогда 85 году сменяла работу и ушла из полиции вот этот..? (Переводчик: Потому что она на пенсии). А, то есть, на пенсии. Понятно. 85 году она на пенсию вышла. Она помнит событие в Ховде в октябре 1989 года, помнит это?***

- *Эмээ, 1989 онд энд нэг оюутнууд жагсаад л, ардчилсан хувьсгал гарахгаад жагсаал цуглаан хийж байсан ш дээ. Ховд, Ховдын Багшийн дээд сургуулийн оюутнууд. Тэр талаар та юу мэдэх вэ?*
- Тэр талаар би сайн мэдэхгүй. Жагсаал болж байна, наануу цаануу гэж ярьж л байсан. Би гадуур дотуур их явадаггүй, тэгэс хийгээд гэр эргээд л байж байдаг болохоор би бас тэрийг сайн мэдэхгүй. Харин тэрийг чинь манай энэ хүн сайн мэдэж байгаа байх, Даймаа.
- **(Interpreter:** Она не так хорошо знает. Просто она слышала, что на площади демонстрация.)
- *Тэгээд эмээ, Та энэ талаар юу гэж бодож байсан бэ? Тухайн үед чинь социализм, соц нийгэм байж байгаад ардчилсан нийгэм болох гэж байсан шилжилтийн үе байсан ш дээ. Тэгээд танд юу гэж бодогдож байв, ардчилсан хувьсгал гээд тэгэхдээр?*
- Ардчилсан хувьсгал энэ их сайн байсан юм уу, социализмын үед сайн байсан юмуу тэрийг нь учрыг нь сайн ялгаж мэдэхгүй, би зүгээр нэг ажилчин ангийн ажилчин албат учрыг нь сайн мэдэхгүй л байсан. Тэр үед тэр ардчилсан үед ороод үзсэн даруйдаа бас нэг жаахан эвгүй болоод ирсэн. Юмнууд чинь талонд ороод, янз бүрийн юмнууд яваад байхаар чинь. Түрүүн байж байсан чинь гурил мурил тэр бүх юм чинь дэлгүүр хоршоонд овоолгоостой байсан. Тэр үед бас бичгийн талон малонд ороод, айл гэр 5 кг гурилаар хэмжигдэх болсон. Энэ чинь очоод яаж байгаа юм бол, ийм хэцүү амьдрал ирдэг юм болов уу гэж жаахан тэнд л санаа зовж байсан байх. Тэрнээс биш учрыг сайн л ойлгохгүй л хоцорч байсан байх л даа, минийхээр.
- **(Interpreter:** Она не так хорошо поняла что происходит. Ну потом когда вещи станут..... она думала что при демократизации, наверно, может быть жизнь такой очень тяжелой. Ну, так она думала.) ***А она помнит что меняла, что такое перестройка, что такое была перестройка, чем... может сказать, ассоциации у нее есть какие-нибудь?***
- *Тухайн үед чинь өөрчлөн байгуулалт гээд нэг юм болж байсан ш дээ, эмээ. Тэр талаар та юу гэж боддог вэ?*

- Юун өөрчлөлт байгуулалтын учрыг сайн мэдээгүй л байсан. Би шинэчлэж байгаа л юм байна гэж бодож байсан байх л даа. Тэрнээс өөрчлөн байгуулалт гэж юу болж байхыг тухайн үед над шиг нэг зүгээр үйлчлэгч ажилчин, жинхэнэ тэр учрыг сайн ойлгохгүй л байх байсан даа.
 - **(Interpreter:** Ну в то время в качестве уборщицы она не так хоршо поняла. Ну думала что обновляет. Обновление происходит. Поэтому образу она поняла перестройку.)
 - **Можно спросить о её детях? О её детях сколько, кто он?**
 - **Танайх хүү хэдэн хүүхэдтэй вэ?**
 - Манайх нэг л хүүхэдтэй.
 - **Одоо хаана, юу хийж амьдарч байна вэ?**
 - Одоо гадаа энэ байшиндаа энд Тагнуулын газарт ажилладаг.
 - **Тагнуулын газар ажилладаг юм уу?**
 - Тагнуулын газарт ажилладаг. Сургуулиа төгсөөд энд ирчихээд Тагнуулын газарт ажилладаг.
 - **Одоо хэдэн настай вэ?**
 - Одоо 41-42- той. 42 хүрч байгаа байх.
 - **(Interpreter:** Единственный сын. Он окончил... работает шпионом. Он живёт в этом доме. Сейчас он лет за сорок один, сорок два.) **А, то есть, в Органах безопасности. Они так сказали шпионом? - Да.**
 - Би нэг юм тодруулах гэсэн юмаа. Таныг Хятадын нутагт төрөөд 29-30 онд энд ирсэн гэлээ л дээ. Тэгэхээр надад их сонин санагдаад. Одоо тэгэж ирсэн хүн монголд их цөөхөн байгаа. Ирсэн улсуудаас амьд мэнд байгаа нь их цөөхөн байгаа байх гэж бодож байна, зайлуул. Тэгээд уг гарлаасаа угаасаа тэр Шинэ монголын одоо тэр Уйгур, Шинжиан уйгуурын нутгийн улсууд байж байгаад тэгээд монгол цэргүүдэд татагдаад ирэв үү эсвэл эндээс дүрвэж гарсан байсныг чинь та нарыг буцааж авчирчсан юм уу. Ямар учиртай юм бэ?
- Talk by a visitor to the house:**
- Уг тэндээ нутагшиж байсан нутгийн гэр. Манай нутаг, байршиж байсан. Тэр Өрөнк Чингэл, Цагаан гол, Салбар Сайр гэдэг чинь тэр манай монголын урианхайн газар. Тэгээд тэнд байж байсан чинь хувьсгал

үүсээд, Сүхбаатар дарга бий болоод. Тэгээд яснаас болоод тэнд цөөхөн монгол айл байсан, казакууд голдуу айлууд. Тэд нарыг наашаа улаан цэргүүд очоод нүүлгэж ирсэн. Казакуудын зарим нь ирсэн, зарим нь цаашаа тэр Шинжиан уйгуур руу л явсан. Одоо тэнд байдаг л байхдаа.

- Ерөнхийдөө тухайн үед болбол тэр монголын бодлого нь тийм байсан юм байна лээ л дээ. Тэнд байгаа газар нутгийг эхлээд хятадтай булаацалдаад, тэгээд ингэхээр монгол хүнээ л буцааж авъяа гэсэн бодлого баримтлаад. Газраа л алдаж байна гэсэн үг л дээ. Цааш нь хүнийг нь татаж авах гээд байсан. Тэгэхээр болохоор өөрсдийнхөө монгол угсааныхаа хүмүүсийг монгол нутагтаа авах тийм л зорилготой нүүлгэж ирсэн. **(Replied by her husband)**
- Тэр одоо тэр, тэнд цөөхөн монголчууд байна аа гэдгийг Сүхбаатар мэдэхгүй ш дээ. Монгол бий болоод тусгаар тогтночиж байхдаа мэдэхгүй байсан. Манай нутгийн ноён хаан болж байлаа. Да лам Чүлтэм гэдэг хүн байж. Тэр хүн очоод Сүхбаатартай уулзаад, бага хурлын гишүүн болоод, тэгээд нутгаа наашаа авчирна, би энд нутагшина, одоо би монгол нутагтаа наашаа ирнэ гэж хэлж. Нутагтаа очоод наашаа ирэх гэхлээр цөөнхийн хэсгийг нь одоо тийм настай тийм хуучин дээр үеийн лам хуврага голдуу тийм улсууд байсан. Тэр цөөхөн улсуудыг, тэр хүнийг цааш нь Хятадын нутаг руу явж байхад Да лам Чүлтэм өрхөмж даавуугаар боогоор барьж явсан. Тэгээд тэр хүн хэлсэн гэж байгаа юм, манай аав хэлсэн, манай аав Лхамба гэж хүн байсан. Манай аав тэр тэгээд хүнийг барьж явж байхад, хэлж тэр, За та нар болшгүй муу юм хийж байна, та нар надад их болбол 2 жил нас, бага болболоод 1 жилийн нас үлдээж байна. Би Сүхбаатартай яриад, бага хурлын гишүүн болоод, ийшээ одоо цөөхөн монголчуудаа нааш нь нүүлгэж ирнэ гэж хэлсэн. Тэгээд тэнд чинь одоо казакууд байсан. Казакаас дайтах гэж байна.. казак монголыг. Казакууд дайтах гэж байна аа түргэн аваарай гэж ийш нь бичиг явуулсан юм нь байна л даа, тэр Сүхбаатарт. Эндээс улаан цэргүүд очоод бид нарыг цөөхөн монголыг нааш нь хамаад түүгээд авчирсан, баруун хязгаараас энэ нутагт авчирсан юм байна. Цааш нь 20-30-аад тэр айлууд Да лам Чүлтэм хэлсэн. Тэгээд хэлсэн: би бага хурлын

гишүүн болоод Сүхбаатарт уулзаад ирсэн. Та нар надад 1-2 жилийн нас өгч байна гэсэн. Хятадын нутагт тэр хүнийг Бээжин дээр очиж цай уу гэж дууджээ. Цай уухгаад очихоор Хятад шинжан түүнийг их ухаантай хүн байна, үүнийг хороохгүй бол болохгүй гээд хороо гэж алсан байна. Та нар надыг явуулсангүй би 2- хон жилийн настай үлдлээ гэж байсан. Тэнд Хятадад очоод 2 дахь жилдээ хороогдсон. Тэгээд үлдсэн хэдэн монголчууд наашаа ирсэн. Чүлтэм Да ламыг манай монголын түүхэнд түүнийг урвагч гэж ордог ш дээ. Тэнд очоод бага хурлын гишүүн, Сүхбаатартай уулзсан. Ирээд Хятад руу явчихсан учраас, урвагч гэж хэлэлгүй яадаг юм. Би тэр үед жаахан байсан. Онгоц очоод, нисдэг ногоон онгоц байж л даа... казак монголчууд наашаа нүүгээд ирсэн. Тэгээд нүүгээд гараад явж байхад чинь би жаахан байсан. Би муухан зүүдэг шиг мэдэж байна. Шөнө нүүж байхад манай ээж намайг морины ард тавьсан байхад би мориноосоо унаж байлаа, тэгээд л аваад л тавьж байсан гэж байгаа юм. Тэгэхлээр би бага байсан байна л даа. Зүүд шиг л мэдэж байна. Онгоц очоод, нисээд л, онгоц ирээд модны мөчир онгоцны сэнсэнд найгаж байсан. Тэгэж байхад чинь казакчууд бас жаахан дайлсан юм шиг байдаг. Тийм л учиртай юм хэлдэг юм байна лээ. Тэгэж л сүүлд манай ээж аав хоёр хоорондоо ярьж байсан. Тийм л юм мэднэ. Тэрүүнээс цаадахыг нь мэдэхгүй шүү.

- Ирээд та бол аав ээжтэйгээ хамт ирсэн юм байна ш дээ. Таньтай цуг ирсэн монголчууд, танай аав ээж хоёр монголд орж ирээд юу хийж байв? Тэд нарын амьдрал ахуй одоо ямар байв? Ер нь энэ одоо монгол засгийн газартаа ер нь ямар, яаж ханддаг байсан юм бол? Ямар газарт харъяалагдаж байсан бол ирээд? **/the visitor/**
- Ирээд энэ Баян-Өлгий аймагт харъяалагдаад, аймаг болоод тогтсоны хойно, аймаг болоогүй байж байхдаа тэр 28-29 онд ямар юманд харъяалагдаж байсныг тэрнийг сайн мэдэхгүй. Тэгээд өөрийнхөө малыг малчин, мал маллаж байсан. Жаахан газар олдвол тариа тариад л, тариагаар амьдардаг, малаараа амьдардаг.

- Ялгаа байхгүй. Газар тариалан эрхлээд л, мал маллаад л. Одоо энд л амьдарч байсан монголчуудтай адилхан амьдарч байсан. Иймээ тиймээ ялгаврлана гэсэн юм байхгүй тухайн үедээ. */Replied by her husband/*
- Сүүлдээ харин тэгээд нилээн жагсана. Тэгээд тэр дайн өнгөрсөний дараа сайхан болоод л. Эх орны чинь...тэр соц германы улсын дайн болж байхад нилээн явдал байсан. Адуу малыг дайнд авч явна. Хөдлөшгүй 5 жилийн төлөвлөгөө гэж өгчихсөн байдаг. Тэр хөдлөшгүй 5 жилийн төлөвлөгөө гэдэг чинь юу билээ гэхлээр 5 малтай байсан чинь, 5 малгүй байсан ч тэр, 5 жилийн төлөвлөгөөний нормыг хэлдэг. Гэхдээ их хатуу чанга байсан. Тэр үед чинь одоо толгойтой тоотой хүмүүсийн эсрэг бөндөгнөдөг байсан. Хүн болгон түгшсэн, айсан тийм л байсан байх. Би тэгэхдээ огт айхаа ч мэдэхгүй, цочхоо ч мэдэхгүй, тэгээд л хоол олдвол идчихээд л явдаг байсан байхдаа. Ээж аавын хэлдгээр болбол тэр үед жаахан хүнд л байсан байна лээ дээ. Аргагүй л дээ шинээр тогтнож байгаа юм чинь тэгээд бий болтлоо бас хэцүү л байдаг байхдаа, тэр чинь. Улс болж тогтнохтоо, тусдаа толгойгоо дагаад яатлаа бас. Одоо бол тийм юм алга байна ш дээ, сайхан байна шүү, айж ичээд ч байх юм байхгүй. Тэр үед чинь толгойтоо тоотой лам тоотныг эсрэг хамж барьж байлаа. Тэр үед чинь би жаахан байсан учраас, та нар яаж мэдэх вэ. Тэр үед чинь би жаахан байсан тэгэхдээ муухан мэдэж л байна. Тэр үед чинь томчууд нилээн айж л байсан байгаа юм. Бид нар чинь ямар айх цочих юм байх биш. Тийм л амьдралтай байсан юм.
- Одоо Хятадын нутагт таны хамаатан саднаас гэдэг юмуу үлдсэн барьсан улсууд байдаг болов уу ?
- Миний аавын хамгийн том эгч хойшоо явсан юм гэнэ билээ. Тэр Чүлтэм Да ламыг хүлээд явж байхад тэнд л хамт тийшээ явсан гэнэ билээ. Нөхөр нь Пунцаг гэдэг хүн байсан тэгээд л тийшээ явсан юм гэнэ лээ. Тэрнээс хойно хэдэн онд билээ энэ чинь Хятад-Монгол хоёр хоорондоо муудалцаад ? 1951 оны үед хэлэлцээр хийгээд уулзахад жагсаал болж байсан, тэгээд би 10 хэдтэй байсан болов уу. Манай тэр аавын том эгч ирээд явсан. Манай энд Булганд ирээд явсан. Зун ирээд, тэгээд ээж байсан, хөгшний ээж манай аавын хажууд байсан. Тэгээд ээжтэйгээ

уулзаад, тэгээд ирээд явсан. Хоёр, гурван хүүхэдтэй айл байсан. Манай ээнд аав очиж, манай тэр эгч орой нь ирээд уулзаад тэгэдэ явсан. Тэрнээс хойш дахиад уулзаж чадаагүй. Нэг хэдэн хүүхдээр дамжиж сураг гарч л байсан нэг үедээ ийшээ тийшээ хүмүүс явж байхад. Одоо тэд нар байх юм уу үгүй мэдэхгүй. Хүүхдүүдийн хүүхэд байдаг л байхдаа. Сургаар нь хэний хүүхдийн хэн нь гэдгийг хэн таних вэ тэрийг одоо. Таних мэдэх хүмүүс байхгүй болсон. Байдаг л байх. Гурван хүүхэдтэй, дөрвөн хүүхэдтэй айл байсан юм гэнэ лээ. Байгаа л байх. Ямар газарт байдгийн тэрийг мэдэх юм алга.

- ***Уучлаарай, Та ямар шашин шүтдэг вэ? Ямар бурхан шүтдэг вэ? / the visitor/***
- Өө, би хуучин корана тэгээд одоо юу л яадаг болохоос биш ... энд нээх шүтээд байх над юм байх биш.
- ***Хуучин бол корана шүтдэг байсан. /the visitor/***
- Хуучин болохоор, тэгээд нэг дээр үед л болохоор нэг бурхан минь ээ л гэдэг хэлэх үгтэй. Цаашдаа надад тийм тахиад шүтээд байдаг тийм лам хар ч байхгүй манайханд, тийм утгаар. Надад одоо тийм шүтээд байдаг юм байхгүй. Хааяа энэ хийдэд нэг очоод хүрчихдэг юм. Ерөөсөө энэ хийд болсноос хойш ганц л удаа очсон байх. Ер нь очиж чаддагүй, явж ч чадахгүй гэрээсээ гарч. Одоо бол хөл муутай, явж чадах биш, гэрээ эргээд л тэгээд байж байна.
- ***Таны хувьд бид нарын сонирхож байгаа 1989 оны 12-р сарын 7-нд болсон тэр оюутны цуглаан, тэрнээс хойш болсон ардчилсан хувьсгалт хөдөлгөөний үеийн Ховдтой холбогдох түүхийн талаар та юу хэлэх вэ ? /the visitor/***
- Тэр ч одоо яахав 1989 оноос урагших үе бол социализм, коммунизмын үе одоо амьдрал гайгүй. Зүгээр авдаг цалингаа аваад, цалин нь тухайн үедээ юмандаа хүрчихдэг ийм боломжийн үе байсан. 1989 онд хувьсгал гэж ардчилал анх гархад Ховд аймгийн Багшийн дээдийн оюутнууд анх жагссан. Тэрийг бол тухайн үед мань мэт бол бас зөв асуудал гэж ойлгож байсан. 1990 онд ч одоо 20-р тогтоол гээд Засгийн газрын тогтоол гарч, тэрүүгээр баллаад хаячихсан. Мөнгөний ханшийг нэг шөнө гаргаад, нэг

өдөр унагаад хаячихсан, мөнгө гээч юу ч биш болоод. Тэгээд бараа материал гэдэг чинь юу ч байхгүй, бүх юм талонтой. Сард нэг 5 кг гурил өгдөг юм уу, нэг хэдэн кг маханд үхтлээ очирлож, 2кг мах авч олж иддэг, ийм байсан. Тэгээд сүүлдээ болбол энэ одоо сайхан л болж байна. Одоо бол юм нь элбэг мөнгөтэй, юм хийдэг залуучууд бобол одоо сайхан амьдарч байна. Тухайн үед бол Багшийн дээдийн тэр жагсаж байсан жагсаал, тэр хэлж байсан үг нь, сайхан үг хэлж байсан тэр нь ч одоо өнөөдөр биелэлээ олж л байна. Сайхан сайхан юмнууд байна, зүгээр саар юмнууд ганц нэг байлгүй яахав. / **Replied by her husband/**

- ***Та нар бол одоо ингээд л анх бол оюутнуудыг, ардчилагчдыг их дэмжиж байж л дээ? /the visitor /***
- Дэмжиж байсан, Ховдынх бол ер нь их дэмжиж байсан. / **Replied by her husband/**
- ***Аа тэгэхтэл, уучлаарай нэг юм асууя. 1992, 1996, 2000, 2004, 2008 энгээд 6 удаагийн сонгуулиар энэ аймгаас монгол ардын хувьсгалт намын улсууд л гараад байсан ш дээ. /the visitor /***
- Голдуу л тэгэж байсан байхаа. Тэгэхдээ болбол гарах үедээ гарч байсан. Яг тийм одоо бүгдэнд нь МАХН-ыг гаргаагүй л дээ. Амаржаргал нэг гарсан. Тэрнээс хойш нээрээ гараагүй байхаа. Энэ жил одоо бас байхгүй. / **Replied by her husband/**
- ***Энэ юутай холбоотой вэ? /the visitor /***
- Энэ бол ард түмний сэтгэл санааны юм байдаг юм уу. Манай Баян-Өлгий, Ховд хоёр голдуу тэгдэг ш дээ, ерөөсөө. Монгол ардын нам гээд л одоо ярьдаг. Увс бол тийм юм байхгүй ш дээ, ардчилалыг их дэмждэг. Бид бол зохих ёсны дэмждэг улсууд байна, байлгүй яахав. Байгаад одоо хүч хүрэхгүй байна ш дээ. Настангуудын, настай улсуудын юм байдаг болов уу голдуу, гэж боддог ш дээ. Тэд нар л дээр үеэсээ л эхлээд монгол ардын хувьсгалт нам гэсээр байгаад л ингэчихсэн. Тэгээд л одоо хүүхэд шуухдаадаа бас яадаг л юм байгаа юм, бас хэлж ярьдаг л байлгүй. Түүнээс биш бид ардчилалыг дэмжилгүй яахав, дэмжнэ ш дээ. Түүнээс биш ямар учиртай юм, яагаад гардаггүй юм, тэрийг нь мэдэхгүй ш дээ. Сонгуульд ордог номоороо ороод санасан хүндээ л өгнө ш дээ.

- Би одоо жаахан юмыг мартдаг, мэдэж байсан юмаа мэддэггүй болоод, сонссон юмаа мартаад, хүн чинь 80-гараад ирэхээр насаар жаахан буурчихдаг юм байна. Залуу насны хийж байсан, сонссон юмаа тэр бүгдийг нь мартаад. Хүүхэд шиг тийм болчихдог юм байна ш дээ, их л мартамгай, муу л болчихдог юм байна.
- *Большое спасибо за этот рассказ. Это очень интересный рассказ, желаю здоровья, благополучия в семье.*
- *За эмээ Танд сонирхолтой зүйл ярилцаж өгсөнд маш их баярлалаа. Тэгээд танд эрүүл энх, сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /Interpreter/*